

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/187/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт	18
4.3 Албан шаардлага.....	18
4.4 Зөвлөмж.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, Имэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/73
танай _____ -ны № _____ -т

**ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ч.БУМДАРЬ ТАНАА**

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020285

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	68,382,423.05	58,293,399.27
35	БАРАА МАТЕРИАЛ	68,382,423.05	58,293,399.27
351	Түүхий эд материал	310,406.00	381,426.00
35110	Тусгай зориулалттай материал	278,426.00	278,426.00
35130	Эм боох материал	31,980.00	103,000.00
354	Хангамжийн материал	62,052,017.05	52,696,973.27
35410	Бичиг хэргийн материал	551,550.00	1,039,002.00
35420	Аж ахуйн материал	3,287,410.00	3,173,550.00
35430	Сэлбэг хэрэгсэл	8,448,902.78	-
35450	Барилгын засварын материал	69,300.00	-
35460	Хүнсний материал	392,237.00	831,416.00
35470	Бусад хангамжийн материал	49,302,617.27	47,653,005.27
35600	Мал амьтад	6,020,000.00	5,215,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,501,327,060.15	2,477,694,330.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,501,327,060.15	2,477,694,330.07
392	Биет хөрөнгө	2,431,781,060.15	2,408,148,330.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,460,589,471.00	2,390,018,471.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(94,938,788.88)	(120,682,660.32)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	10,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,666,666.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	129,333,728.00	99,327,350.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(103,466,588.16)	(14,852,710.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,255,439.74	46,894,392.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,163,073.82)	(18,321,988.08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,172,860.00	7,964,002.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,095,127.27)	(2,960,000.00)
39217	Ном	13,093,139.54	13,428,139.54
393	Биет бус хөрөнгө	69,546,000.00	69,546,000.00
39301	Програм хангамж	784,500.00	784,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(784,500.00)	(784,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	69,546,000.00	69,546,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,569,709,483.20	2,535,987,729.34
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,569,709,483.20	2,535,987,729.34
51	Засгийн газрын хувь оролцоо	2,569,709,483.20	2,535,987,729.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	602,708,368.54	602,708,368.54
51101	Өмч: - төрийн	602,708,368.54	602,708,368.54
512	Хуримтлагдсан үр дүн	1,036,103,736.98	1,194,929,176.12
51210	Өмнөх үеийн үр дүн	(96,006,630.00)	1,228,650,929.98
51220	Тайлант үеийн үр дүн	1,132,110,366.98	(33,721,753.86)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	930,897,377.68	738,350,184.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,569,709,483.20	2,535,987,729.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,174,211,234.80	1,366,367,525.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,983,069,114.00	1,137,443,843.40
120	Нийтлэг татварын бус орлого	1,206,052,414.00	415,474,243.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,206,052,414.00	415,474,243.40
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,206,052,414.00	415,474,243.40
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	777,016,700.00	721,969,600.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	777,016,700.00	721,969,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	191,142,120.80	228,923,682.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,614,100.00	49,353,282.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,614,100.00	49,353,282.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	164,528,020.80	179,570,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	164,528,020.80	179,570,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,040,119,314.32	1,027,637,527.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,040,119,314.32	1,027,637,527.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	908,079,767.52	956,154,420.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	560,622,024.66	571,233,331.26
210101	Үндсэн цалин	547,361,494.66	395,447,405.17
210102	Нэмэгдэл		175,785,926.09
210104	Урамшуулал	13,260,530.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,248,790.54	76,559,482.30
210201	Тэтгэврийн даатгал	47,652,891.00	52,940,795.60
210202	Тэтгэмжийн даатгал	6,617,634.54	6,880,194.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,484,977.00	4,494,605.70
210204	Ажилгүйдлийн даатгал	1,044,845.00	1,108,580.40
210205	Эрүүл мэндийн даатгал	10,448,443.00	11,135,306.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	162,928,020.80	195,479,306.59
210301	Гэрэл, цахилгаан	7,019,320.80	5,479,726.59
210302	Түлш, халаалт	153,708,700.00	187,199,580.00
210303	Цэвэр, бохир ус	2,200,000.00	2,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,255,576.00	17,145,555.78
210401	Бичиг хэрэг	2,112,100.00	591,350.00
210402	Тээвэр, шатахуун	463,570.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	279,100.00	711,565.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,507,690.00	3,999,260.00
210408	Бараа материал акталсны зардал	3,871,766.00	11,343,380.78
2105	Нормативт зардал	30,061,483.14	13,604,822.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	190,260.00	178,980.00
210502	Хоол, хүнс	29,871,223.14	12,508,192.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		917,650.00

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	456,200.00	1,069,300.00
210604	Урсгал засвар	456,200.00	1,069,300.00
2107	Томилолт, зочны зардал	126,000.00	223,000.00
210702	Дотоод албан томилолт	126,000.00	223,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	708,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	708,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,673,672.38	80,839,622.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,276,665.74	5,430,701.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	485,200.00	1,336,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	63,911,806.64	74,072,921.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	132,039,546.80	71,483,106.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,154,100.00	38,905,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		16,803,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	7,261,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	26,514,100.00	14,261,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	640,000.00	579,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	6,333,973.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		6,333,973.41
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	104,885,446.80	26,243,433.44
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	104,885,446.80	26,243,433.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,134,091,920.48</u>	<u>338,729,997.87</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	600,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз		600,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,981,553.50	373,051,751.73
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,981,553.50	373,051,751.73
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,981,553.50)	(372,451,751.73)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,132,110,366.98</u>	<u>(33,721,753.86)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	602,708,368.54	930,932,843.68	-96,042,096.00	1,437,599,116.22
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	35,466.00	35,466.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	602,708,368.54	930,932,843.68	-96,006,630.00	1,437,634,582.22
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	-35,466.00	0.00	-35,466.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,132,110,366.98	1,132,110,366.98
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	602,708,368.54	930,897,377.68	1,036,103,736.98	2,569,709,483.20
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	602,708,368.54	930,897,377.68	1,036,103,736.98	2,569,709,483.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	602,708,368.54	930,897,377.68	1,036,103,736.98	2,569,709,483.20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	192,547,193.00	192,547,193.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	192,547,193.00	0.00	-192,547,193.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-33,721,753.86	-33,721,753.86
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	602,708,368.54	738,350,184.68	1,194,929,176.12	2,535,987,729.34

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>968,158,820.80</u>	<u>950,893,282.00</u>	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	777,016,700.00	721,969,600.00	
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	777,016,700.00	721,969,600.00	
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	777,016,700.00	721,969,600.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	191,142,120.80	228,923,682.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,614,100.00	49,353,282.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,614,100.00	49,353,282.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	164,528,020.80	179,570,400.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	164,528,020.80	179,570,400.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>967,860,820.80</u>	<u>943,173,782.00</u>	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	967,860,820.80	943,173,782.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	822,714,116.00	866,977,668.15	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	560,526,542.70	571,233,326.73	
210101	Үндсэн цалин	351,290,388.82	328,315,119.80	
210102	Нэмэгдэл	160,473,522.48	242,918,206.93	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,342,000.00		
210104	Урамшуулал	37,420,631.40		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,344,272.50	76,559,486.83	
210201	Тэтгэврийн даатгал	48,420,981.77	53,756,277.71	
210202	Тэтгэмжийн даатгал	5,499,198.28	5,795,857.61	
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,392,519.02	4,575,915.86	
210204	Ажилгүйдлийн даатгал	1,091,550.95	1,110,092.86	
210205	Эрүүл мэндийн даатгал	10,940,022.48	11,321,342.79	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	163,528,020.80	195,479,306.59	
210301	Гэрэл, цахилгаан	7,019,320.80	5,479,726.59	
210302	Түлш, халаалт	153,708,700.00	187,199,580.00	
210303	Цэвэр, бохир ус	2,800,000.00	2,800,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	4,916,950.00	3,857,802.00	
210401	Бичиг хэрэг	264,000.00	637,802.00	
210402	Тээвэр, шатахуун	464,000.00	500,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	720,000.00	750,000.00	
210404	Ном, хэвлэл	39,850.00		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	165,000.00	160,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,264,100.00	1,810,000.00	
2105	Нормативт зардал	18,781,980.00	14,947,246.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	140,000.00	500,000.00	
210502	Хоол, хүнс	17,289,980.00	12,957,246.00	

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,352,000.00	1,490,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	126,000.00	223,000.00
210702	Дотоод албан томилолт	126,000.00	223,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	708,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	708,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,782,350.00	3,677,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	163,600.00	1,400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,618,750.00	2,277,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	145,146,704.80	76,196,113.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,261,258.00	43,618,707.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,743,158.00	21,175,607.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	7,261,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	26,514,100.00	14,261,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,004,000.00	920,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	6,333,973.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		6,333,973.41
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	104,885,446.80	26,243,433.44
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	104,885,446.80	26,243,433.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	298,000.00	7,719,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	298,000.00	7,719,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	298,000.00	7,719,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	298,000.00	7,719,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	298,000.00	7,719,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(298,000.00)	(7,719,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	(0.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	901,540,000.00	875,296,566.56	26,243,433.44	97.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	901,540,000.00	875,296,566.56	26,243,433.44	97.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	876,737,300.00	853,200,459.56	23,536,840.44	97.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	584,131,900.00	571,233,326.73	12,898,573.27	97.79
210101	Үндсэн цалин	389,674,700.00	328,315,119.80	61,359,580.20	84.25
210102	Нэмэгдэл	136,086,200.00	242,918,206.93	(106,832,006.93)	178.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,857,800.00	76,559,486.83	2,298,313.17	97.09
210201	Тэтгэврийн даатгал	55,494,600.00	53,756,277.71	1,738,322.29	96.87
210202	Тэтгэмжийн даатгал	5,843,400.00	5,795,857.61	47,542.39	99.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,674,700.00	4,575,915.86	98,784.14	97.89
210204	Ажилгүйдлийн даатгал	1,169,700.00	1,110,092.86	59,607.14	94.90
210205	Эрүүл мэндийн даатгал	11,675,400.00	11,321,342.79	354,057.21	96.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	178,570,400.00	178,570,400.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	11,813,700.00	5,479,726.59	6,333,973.41	46.38
210302	Түлш, халаалт	163,956,700.00	170,290,673.41	(6,333,973.41)	103.86
210303	Цэвэр, бохир ус	2,800,000.00	2,800,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,095,000.00	4,095,000.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	350,000.00	350,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	500,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	750,000.00	750,000.00	-	100.00
210404	Ном, хэвлэл	335,000.00	335,000.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.00	160,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	24,597,200.00	16,257,246.00	8,339,954.00	66.09
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.00	500,000.00	-	100.00
210502	Хоол, хүнс	21,297,200.00	12,957,246.00	8,339,954.00	60.84
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,800,000.00	2,800,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	223,000.00	223,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	223,000.00	223,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,662,000.00	5,262,000.00	(600,000.00)	112.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	1,400,000.00	(600,000.00)	175.00

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,862,000.00	3,862,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,802,700.00	22,096,107.00	2,706,593.00	89.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,802,700.00	22,096,107.00	2,706,593.00	89.09
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,882,200.00	21,175,607.00	2,706,593.00	88.67
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	920,500.00	920,500.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	901,267,000.00	875,296,566.56	25,970,433.44	97.12
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	721,696,600.00	695,726,166.56	25,970,433.44	96.40
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	721,696,600.00	695,726,166.56	25,970,433.44	96.40
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	179,570,400.00	179,570,400.00	-	100.00
122005	Орон нутгийн төсвөөс	179,570,400.00	179,570,400.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	46.00	46.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	32.00	32.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,614,100.00	43,019,308.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,614,100.00	43,019,308.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	21,496,708.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	16,908,906.59
210302	Түлш, халаалт	-	16,908,906.59
2104	Хангамж, бараа материалын зардал	-	287,802.00
210401	Бичиг хэрэг	-	287,802.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	4,300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,614,100.00	21,522,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,614,100.00	21,522,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	7,261,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	26,514,100.00	14,261,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	26,614,100.00	43,019,308.59
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,614,100.00	43,019,308.59
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,614,100.00	43,019,308.59

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор С.Батжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургууль нь сургуулийн аюулгүй, сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлж, сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэхийг эрхэм зорилгоо болгон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн Дотоод хяналтын баг нь 2021 онд үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, тайлант хугацаанд 14 чиглэлээр хяналт шалгалтын ажил гүйцэтгэсэн байна.

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургууль нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг.

Тайлант онд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын

гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөвт зардал 901,540.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,523.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10,142.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Гүүксофт” ХХК-ний “Dynamic” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 901,540.0 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 43,019.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 943,173.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 337,998.6 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 10,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 64,826.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 6,994.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 335.0 мянган төгрөгийн ном, 5,004.0 мянган төгрөгийн бусад хөрөнгө, нийт 425,158.6 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 7,719.5 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 1,890.0 мянган төгрөгийн, балансаас баланст шилжүүлэн авсан 10,000.0 мянган төгрөгийн, хөрөнгийн дахин үнэлгээ хийгдсэн 405,549.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 1,591.8 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 46,560.2 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 58,241.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дангүй байна. Бараа материал 58,293.4 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 2,477,694.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-		-
Авлага			-
Урьдчилгаа			-
Бараа материал	68,382.4	58,293.4	(10,089.0)
Үндсэн хөрөнгө	2,501,327.1	2,477,694.3	(23,632.8)
Нийт хөрөнгө	2,569,709.5	2,535,987.7	(33,721.8)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,569,709.5	2,535,987.7	(33,721.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,569,709.5	2,535,987.7	(33,721.8)

Бараа материалын дансны үлдэгдэл 58,293.4 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 10,089.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,477,694.3 мянган төгрөг болж 33,721.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлж бүртгэлд тусгаснаас шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,535,987.7 мянган төгрөг болж 33,721.8 мянган төгрөгөөр буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 901,540.0 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 876,737.3 мянган төгрөг, татаас ба урсгал шилжүүлгийн зардалд 24,802.7 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 876,737.3 мянган төгрөгийн урсгал зардал, 24,802.7 мянган төгрөгийн татаас ба урсгал шилжүүлгийн зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 901,540.0 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 875,296.6 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 26,243.4 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 875,296.6 мянган төгрөг буюу 97.1 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 43,019.3 мянган төгрөг төвлөрч, урсгалд зардалд 43,019.3 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 337,998.6 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 10,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 64,826.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 6,994.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 335.0 мянган төгрөгийн ном, 5,004.0 мянган төгрөгийн бусад хөрөнгө, нийт 425,158.6 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 7,719.5 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 1,890.0 мянган төгрөгийн, балансаас баланст шилжүүлэн авсан 10,000.0 мянган төгрөгийн, хөрөнгийн дахин үнэлгээ хийгдсэн 405,549.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн “Хөрөнгө шийдвэрлэх тухай” 07 дугаар тушаалаар 2020 оны жилийн эцсийн тооллогоор ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй болсон 2,380.6 мянган төгрөгийн хөрөнгө, 1,498.5 мянган төгрөгийн бараа материалыг акталсан.

3.8 Аудитын гол асуудал

Бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 11 нэр төрлийн 9,408.5 мянган төгрөгийн үнэ бүхий тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, программ хангамж бүртгэлтэй, өмнөх аудиаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс 136 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 9 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 2 албан шаардлага, 7,781.0 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлөөс 2 алдаа зөрчил давтан гарч байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10,370.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 10,193.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 177.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа гараагүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

Аудитаар зөрчил арилгах 10,193.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 11 нэр төрлийн 9,408.5 мянган төгрөгийн үнэ бүхий тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, программ хангамж бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгаа нь: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 тоот тогтоол, УСНББОУС 12-той тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 4 нэр төрлийн 784.5 мянган төгрөгийн үнэ бүхий үлдэх өртөггүй биет бус хөрөнгө бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд ажил олгогчоос төлөх 177.0 мянган төгрөгийн НДШ-ийг Цалингийн зардлаас гүйлгэн шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэнтэй нийцэхгүй, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх

2. Шилэн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 136 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 9 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургууль	4	10,370.0	-	-	-	-	2	10,193.0	2	177.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn